



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

АРДЧИЛСАН НАМД

2024.08.09

№

422

танай

-ны №

-т

Хандивын тайлангийн дүгнэлт

Орон нутгийн Хурлын ээлжит сонгуульд оролцохоор “Ардчилсан нам”-аас ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Төрийн Аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох нам нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-д заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.7-д заасны дагуу Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүргийг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, мөн хуулийн 16 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт, зааврын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.

Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Намаас дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулахгүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага хүлээхгүй болно.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын газар нь Орон нутгийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Ардчилсан намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны А/49 дугаар тушаалаар батлагдсан зааврыг баримтлан Аймаг, нийслэл, сум, дүүргийн

иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.1, 55.1.2, 55.1.3, 55.1.4, 55.1.5, 55.1.6, 55.1.7-д нийцэж буй эсэхийг дэмжих нотлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулж, дүгнэлт гаргасан болно.

Дүгнэлт

Ардчилсан нам нь 2024 оны ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хандив аваагүй байна.

Хувийг: Завхан аймгийн Сонгуулийн хороонд

ДАРГА, ТӨРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА